

AUDIT

Үндэсний компаниудын дотоод аудитын төлөвшлийн судалгаа, дүгнэлт

А.Өнөржаргал Доктор (Ph.D)

Хураангуй

Сүүлийн жилүүдэд аж ахуйн нэгж, байгууллагад дотоод хяналтын эрэлт өсч, компанид дотоод аудитын алба, нэгжийг байгуулах болсон. Энэхүү өгүүлэлд үндэсний компаниудад хэрэгжиж буй дотоод аудитын хөгжлийн өнөөгийн байдалд дүгнэлт өгөх, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, түүнчлэн компанийн дотоод аудитын удирдлага, зохион байгуулалт, арга зүйг боловсронгуй болгоход чиглэсэн санал, зөвлөмжийг дэвшүүлэх зорилгоор хийсэн судалгааны зарим үр дүнг толилуулж байна.

Abstract

Research and Analyses of Internal Auditing of National Companies. In recent years as a result of importance of internal auditing, business entities and companies create internal audit department. This research is focused on results of analyses on current situation of internal auditing principles within the company, determining the problems and legal aspects the company faces today; suggestions how to improve management, structure and methods of implementing internal auditing principles in the company.

Оршил

1930-аад оны дэлхийн эдийн засгийн хямралын дараа удирдлагын төлөвлөлт, дотоод хяналтын чиг үүргийг илүүтэй авч үздэг контроллингийн онолын үзэл баримтлал аудитад хүчтэй хөгжсөн, мөн хувьцаат компанийн санхүүгийн тайланд аудит хийх эрх зүйн шаардлага бий болж, хөндлөнгийн аудитаар байгууллагын дотоод хяналтын системийн үр ашгийг үнэлэх болсон зэрэг нь компанийн удирдлагын зүгээс

дотоод хяналтаа сайжруулах эрэлтийг бий болгож 1940-өөд оны эхээр АНУ-д дотоод аудит үүсэх үндсэн нөхцлийг бүрдүүлсэн.

Бизнесийн хөгжлийг даган дотоод аудитын удирдлагад гүйцэтгэх үүрэг, хамрах хүрээ, арга зүй өргөжин хөгжсөөр өнөөдөр компанийн өмчлөгчид, хөрөнгө оруулагчдыг үйл ажиллагааны үр ашиг, үр дүнгийн талаарх мэдээллээр хангаж, тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн компанийн сайн засаглалын нэг элемент болж, удирдлагад үйл ажиллагааг сайжруулах зөвлөгөө өгснөөр бизнесийн эрсдлийг бууруулахад чиглэсэн удирдлагын орчин үеийн арга хэрэгслийн үүргийг гүйцэтгэх болсон. Дотоод аудит нь "байгууллагын үйл ажиллагааг сайжруулж, үнэ цэнийг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодит баталгаа өгч зөвлөх үйлчилгээ бөгөөд эрсдлийн удирдлага, дотоод хяналт, засаглалын үйл ажиллагааны үр ашгийг үнэлэх болон сайжруулахад чиглэн зохион байгуулалттай, эмх цэгцтэй хандлагыг хэрэглэснээр байгууллагын өмнөө тавьсан зорилгодоо хүрэхэд нь туслана"¹. Манай улсад арилжааны банкуудад анхны дотоод аудитын алба үүссэн бөгөөд 2010 оноос хойш эрх зүйн орчны зарим элементүүд бүрдэж, үндэсний томоохон компаниудад дотоод аудит бий болох үйл явц эрчимтэй явагдаж байна². Гэвч өмчийн эзэд, бизнес эрхлэгчид төдийгүй төр засаг, судлаачдын хүрээнд байгууллагын дотоод хяналт, дотоод аудитын тогтолцоо, удирдлагад гүйцэтгэх үүргийн талаар нэгдсэн ойлголтод хүрээгүй, компанид дотоод аудитыг

1 International standards for the professional practice of internal auditing, The Institute of Internal Auditors.2009.
2 А.Өнөржаргал. Компанийн дотоод аудитын онол, арга зүйн асуудал (нэг сэдэвт бүтээл). 2014

зохион байгуулах болон хэрэгжүүлэх арга зүйн удирдамж дутагдалтай байгаа юм. Иймд компанийн дотоод хяналтын нэг хэлбэр болж шинэ тутам хөгжиж буй дотоод аудитыг олон улсын жишиг, компанийн сайн засаглалын туршлагад тулгуурлан зөв төлөвшүүлж, бизнесийн эрсдлийг бууруулахад чиглэсэн удирдлагын орчин үеийн арга хэрэгсэл болгон хөгжүүлэх шаардлагатай байна.

Судалгааны мэдээлэл

Судалгаанд үндэсний 25 компанийг хамруулсан бөгөөд үүнээс 11 нь төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой (МИАТ ХК, УБТЗ ХНН, ДЦС-3 ХК, УБ Цахилгаан түгээх сүлжээ ХК, УБ Дулааны сүлжээ ХК, Эрдэнэт үйлдвэр ХХК, Монголросцветмет, Мэдээлэл холбооны сүлжээ ХК, МЦХолбоо ХК, Хөгжлийн банк, Цахилгаан түгээх үндэсний сүлжээ ХК), 14 компани нь хувийн өмчийн (ХААН, Хадгаламж, Худалдаа хөгжлийн, Голомт, Хас банкууд, Номин холдинг ХХК, Оюу толгой ХХК, Скайтел ХХК, М-Си-Эс холдинг ХХК, Талх чихэр ХК, УБ хивс ХК, Атар өргөө ХК, Магнайтрейд групп ХХК, Шунхлай групп ХХК) бөгөөд 10 нь хувьцаат компани, 15 нь хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Эдгээр компани нь олон жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа үндэсний нэр хүнд бүхий томоохон компаниуд бөгөөд 2013 оны байдлаар бүгд дотоод аудитын албатай.

Судалгааны загвар

Компанид үр ашигтай дотоод аудитын тогтолцоо бүрдүүлэхэд дотоод аудитын зорилгыг зөв тодорхойлж, түүнд нийцсэн удирдлага, зохион байгуулалтын бүтэц бий болгох, үйл ажиллагааны хамрах хүрээ, арга зүй оновчтой байх, мөн дотоод аудиторудын мэдлэг, мэргэжлийн үр чадвар чухал нөлөөтэй тул компаниудын дотоод аудитын хөгжлийг дээрх үзүүлэлтүүдийг багтаасан дараах үндсэн дөрвөн чиглэлээр үнэллээ. Үүнд:

1. дотоод аудитын эрэлтэд нөлөөлж буй хүчин зүйл;
2. дотоод аудитын нэгжийн зохион байгуулалт;
3. дотоод аудитын үйл ажиллагааны хамрах хүрээ, арга зүй;
4. хүний нөөц (дотоод аудиторуд).

Компанид дотоод аудит бий болоход нөлөөлж буй хүчин зүйлс

Компанийн засаглалын талаарх зөвлөмжийн баримт бичгүүдийн агуулгаас үзвэл компанид дотоод аудитын эрэлтийг бий болгох үндсэн хүчин зүйлс нь:

- хууль, эрх зүйн шаардлага (хууль болон бусад эрх зүйн баримт бичигт дотоод аудиттай байхаар заах);
- засаглах болон гүйцэтгэх удирдлагын зааглалт (гүйцэтгэх удирдлага нь өмчлөгчидтэй хийсэн гэрээний үндсэн дээр менежментийг хэрэгжүүлэх);
- нийтийн эзэмшлийн компаниуд (олон хувьцаа эзэмшигчидтэй байх);
- нийтийн ашиг сонирхлын компаниуд (нийтийн ашиг сонирхлыг хөнддөг үйл ажиллагаа эрхлэх);
- бизнесийн өргөжилт (компанийн үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэж, олон салбар нэгжтэй болох) юм.

Манай компаниудад дотоод аудитын эрэлт бий болоход чухам аль хүчин зүйл илүү нөлөөлж байгааг тогтоох зорилгоор онолын хүчин зүйлийн шинж тэмдэг байвал 1, эсрэг тохиолдолд 0 гэсэн утгыг оруулан харьцуулалт хийж үзэхэд бизнесийн өргөжилт (олон салбар нэгжтэй болж толгой компанийн зүгээс салбар охин компанийн удирдлагын үйл ажиллагааг хянах) нь дотоод аудит бий болох үндсэн хүчин зүйл болж байна. Харин олон хувьцаа эзэмшигчидтэй байх (28 хувь), эрх зүйн шаардлага (24 хувь) зэрэг нь манай компаниудад дотоод аудитыг хэрэгжүүлэх нийтлэг хүчин зүйл болж чадахгүй байна. Энэ нь манай компаниудын хувьцааны дийлэнх хэсгийг нэг гэр бүл юмуу нэгдмэл сонирхолтой этгээдүүд эзэмшдэгээс өмчийн эзэд засаглах болон гүйцэтгэх удирдлагын аль алиныг нь давхар гүйцэтгэдэг, банкнаас бусад ялангуяа нийтийн ашиг сонирхлын компаниудад дотоод аудитыг заавал хэрэгжүүлэх эрх зүйн заалт байхгүйтэй холбоотой. Үндэсний компаниудын дотоод аудитын алба 2-оос 50 орчим хүний бүрэлдэхүүнтэй дотоод аудитын нэгжтэй бөгөөд 11 компани (44 хувь) 10 хүртэл, 7 компани (28 хувь) 10-аас 20 хүртэл ажилтантай, 7 компани (28 хувь) 20-оос дээш ажилтантай байна. Ажилтнуудын тооноос хамааруулан эдгээр компаниудын дотоод аудитын албыг том, дунд, бага гэж ангилж үзэж болохоор байна.

Дотоод аудитын алба нь 23-аас 50 хүртэл ажилтантай ХААН банк, Хадгаламж банк,

Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, МИАТ ХК, УБ Төмөр зам, Номин холдинг ХХК-уудыг том хэмжээний, 10 аас 20 орчим ажилтантай ДЦС 3 ХК, УБ Цахилгаан түгээх сүлжээ ХК, УБ Дулааны сүлжээ ХК, Мэдээлэл холбооны сүлжээ зэрэг ихэвчлэн төрийн өмчийн компаниудыг дунд гэсэн зэрэглэлд хамааруулж болох юм. Харин дотоод аудитын алба нь 10 хүртэл ажилтантай МЦХ ХК, ЦТҮС ХК, Монросцветмет, Скайтел ХХК, Эм-Си-Эс холдинг ХХК, Шунхлай групп ХХК, Оюу толгой ХХК зэрэг ихэвчлэн хувийн өмчийн компаниудын дотоод аудитын алба нь бага гэсэн ангилалд орж байна. Компанийн дотоод аудитын албаны бүтэц, зохион байгуулалт, хэмжээ нь түүний үйл ажиллагааны цар хүрээ (салбар нэгжийн тоо, нийт ажиллагчдын тоо, дотоод аудитын үр өгөөж г.м)-нээс хамаарна. Манай компаниудын дотоод аудитын алба томорч өргөжихөд чухам аль хүчин зүйл нь илүү нөлөөлж буйг тогтоох зорилгоор Пирсоны корреляцийн коэффициентыг тооцож хүснэгт 1-д харуулав.

Хүчин зүйлүүдийн хоорондын хамаарлын коэффициент

Хүснэгт 1

Үзүүлэлт	Салбар, нэгжийн тоо	Ажиллагчдын тоо	ДА-ын албаны ажилласан хугацаа
Пирсоны коэффициент	0,734(**)	0,240	0,501(*)
Ач холбогдлын түвшин	0,001	0,248	0,011

** 0.01 түвшинд хамаарал нь ач холбогдолтой.

* 0.05 түвшинд хамаарал нь ач холбогдолтой.

Хүснэгтээс харахад компанийн дотоод аудитын албаны хэмжээ нь статистикийн ач холбогдлын түвшинд салбар нэгжийн тоотой ($r=0.734$) хүчтэй, дотоод аудитын албаны ажилласан жилтэй ($r=0.501$) дунд зэргийн хамааралтай, харин нийт ажиллагчдын тоотой хамааралгүй байна. Эндээс үзэхэд компанийн үйл ажиллагаа өргөжин, салбар нэгжийн тоо олон болох тусам дотоод аудитын албаны хэмжээ том (олон дотоод аудитортой) байна. Мөн компанийн дотоод аудитын албаны үйл ажиллагаа явуулсан хугацаанаас хамаарч дотоод аудиторуудын тоо нэмэгдэж байгааг харуулж байна. Харин дотоод аудитын албаны хэмжээ нь компанийн нийт ажиллагчдын

тооноос төдийлөн их хамаарахгүй байна.

Дотоод аудитын нэгжийн зохион байгуулалт

Компанийн сайн засаглалын талаарх зөвлөмжийн баримт бичгүүдэд дотоод аудитыг өмчлөгчдөд шууд харьяалуулж, гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулах нь үр дүнтэй гэж үздэг. Гэхдээ дотоод аудитын удирдлагын харьяалал нь түүний зорилгоос хамаарна. Манай компаниудын дотоод аудитын зорилго нь компанийн өмчлөлийн хэлбэрээс хамаарч ялгаатай тодорхойлогдож байна. Төрийн өмчийн компаниудын дотоод аудит нь дотоод хяналтын дүрэм журам боловсруулах, хяналтын оновчтой горимуудыг хэрэгжүүлэх (36 хувь), хөдөлмөрийн болон техникийн аюулгүй ажиллагааны найдвартай байдлыг хангах (36 хувь) зэрэг үндсэн зорилготой байгаас үзэхэд гүйцэтгэх удирдлагын гаргасан шийдвэрийн биелэлтийг хангахад чиглэсэн дотоод хяналтыг хэрэгжүүлэх нийтлэг зорилготой байна. Харин хувийн өмчийн компаниуд дотоод аудит нь компанид дотоод хяналтыг хэрэгжүүлэх (45 хувь), эрсдэл, хяналтын тогтолцоонд үнэлэлт, дүгнэлт өгч сайжруулах зөвлөмж гаргах (40 хувь), өмчлөгчдийн нэрийн өмнөөс гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж үнэлэх, зөвлөх (40 хувь) гэж тодорхойлсон байгаагаас үзэхэд гүйцэтгэх удирдлагын гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах дотоод хяналтыг хэрэгжүүлэхээс гадна өмчлөгчдийн өмнөөс гүйцэтгэх удирдлагыг хянах зорилготой байгаа нь харагдаж байна. Удирдлагын харьяалалыг авч үзвэл 7 компанийн дотоод аудитын алба нь ТУЗ-д, 18 компанийн дотоод аудит нь гүйцэтгэх удирдлагадаа харьяалагдаж байна. Өмчлөлийн хэлбэрээр нь авч үзвэл төрийн өмчийн 11 компанийн нэг (Хөгжлийн банк)-ээс бусад компанийн дотоод аудит гүйцэтгэх удирдлагадаа харьяалагдаж байгаа бол хувийн өмчийн 6 компанийн дотоод аудит ТУЗ-д, 8 компанийн дотоод аудит гүйцэтгэх удирдлагадаа харьяалагдаж байна (дүрслэл 1). Дотоод аудитын удирдлагын харьяалал нь түүний зорилгоос хамаарч ялгаатай байгаа бөгөөд өмчлөгчдийн зүгээс гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хянаж үнэлэлт, дүгнэлт өгөх зорилготой бол ТУЗ-д, харин гүйцэтгэх удирдлагын шийдвэрийн биелэлтийг хангах дотоод хяналтыг хэрэгжүүлж, охин компаниуд болон салбар нэгжийн үйл ажиллагааг хянах зорилготой бол гүйцэтгэх

удирдлагад харьяалагдах нь нийтлэг байна. Хөгжлийн банкнаас бусад төрийн өмчийн бүх компаниудын дотоод аудит нь гүйцэтгэх удирдлагад харьяалагдаж байгаа нь төрийн зүгээс өмчлөгчийн эрх, үүрэг, хяналтыг ТУЗ-аар дамжуулан хэрэгжүүлдэг жишиг манай төрийн өмчийн компаниудад тогтоогүй, ТУЗ нь эдгээр компаниудын засаглалд тодорхой үүрэг гүйцэтгэдэггүй тул гүйцэтгэх удирдлага өмчийн эзний байр сууринаас хандан ажилладагтай холбоотой.

Дүрслэл 1

Төрийн ба хувийн өмчит компаниудын дотоод аудитын албаны харьяалал



Харин хувийн өмчийн компаниудын хувьд засаглах болон гүйцэтгэх удирдлага нэг байгаагаас өмчлөгчдийн зүгээс гүйцэтгэх удирдлагыг хянах шаардлага нийтлэг байдлаар үүсээгүй, дотоод аудит нь гүйцэтгэх удирдлагын хяналтын үүргийг хэрэгжүүлэх зорилготой байгаа нь дотоод аудит нь гүйцэтгэх удирдлагад харьяалагдах шалтгаан болж байгаа юм.

Дотоод аудитын үйл ажиллагааны хамрах хүрээ, арга зүй

Бизнесийн үйл ажиллагааны бүх талын дотоод хяналт, эрсдлийн удирдлагын тогтолцоог үнэлэх, сайжруулахад чиглэгддэг дотоод аудитын үндсэн үүрэгтэй харьцуулж үзвэл манай компаниудын дотоод аудитын үйл ажиллагааны 70-80 хувь нь хууль бус үйлдэл, хөрөнгийн зүй бус ашиглалтыг шалгаж илрүүлэх, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын найдвартай байдал, хууль дүрэм журмын хэрэгжилтийг шалгаж дүгнэх, санхүүгийн тайлагналын үнэн зөвийг баталгаажуулахад чиглэгдэж байна (дүрслэл 2). Үүнийг нэг талаас нь санхүүгийн ба нийцлийн дотоод аудит хийгдэж байна гэж үзэж болох боловч энэ чиглэлээр учирч болзошгүй эрсдэл, дотоод хяналтыг үнэлэхээс илүүтэйгээр шалгах, үнэлэлт өгөхөд чиглэсэн үйл ажиллагаа давамгайлж байгаа нь дотоод аудит манайд санхүүгийн хяналт, шалгалтын агуулгыг хадгалсаар байгааг харуулж байна. Компаниудын дотоод аудит нь тайлан мэдээний үнэн зөвийг баталгаажуулах, үйл ажиллагааны үр ашгийг тооцох, хууль эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгах зэрэг ихэвчлэн өнгөрсөн хугацааны үйл ажиллагааг үнэлж дүгнэхэд чиглэгдэж, харин орчин үеийн дотоод аудитын үндсэн үүрэг болох бизнесийн бүх талбарт учирч болзошгүй эрсдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зөвлөмж өгөх үйл ажиллагаанд төдийлөн хандаж чадахгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Дүрслэл 2

Дотоод аудитын үйл ажиллагааны хамрах хүрээ



Бизнесийн хөгжил, гадаад, дотоод орчны хувьсал өөрчлөлт, мэдээллийн технологийн хөгжилтэй уялдаж дотоод аудитын арга зүй байнга хөгжиж шинэчлэгддэг зүй тогтолтой. Судлаачид аудитын хөгжлийн явцад бий болсон арга зүйн үндсэн гурван хандлагыг тодорхойлдог бөгөөд энэ нь нотлох үйл

ажиллагааны аудит (уламжлалт хандлага), системт баримжааллын аудит, эрсдэлд суурилсан аудит³ юм. Эрсдэлд суурилсан дотоод аудитын арга зүйг аудитын орчин үеийн арга гэж үзэж байгаа бөгөөд Дотоод аудитын олон улсын стандартад дотоод аудитын төлөвлөлтийг эрсдэлд суурилж хийхийг шаарддаг. Манай компаниудын дотоод аудитын объектыг сонгож, ажлаа төлөвлөх үндэслэл нь тухайн компанийн өмчлөлийн хэлбэрээс хамаарч байгаа бөгөөд төрийн өмчийн компаниудын дотоод аудитын алба нь гүйцэтгэх удирдлагын (78 хувь), харин хувийн өмчийн компаниудад гүйцэтгэх удирдлагаас гадна ТУЗ-ийн гишүүдийн өгсөн үүрэг даалгавар, чиглэлийг (53 хувь) баримталж аудитын объектыг сонгон төлөвлөж байна. Үүнээс гадна дотоод аудитын төлөвлөлтөд өмнөх аудитаар илэрсэн зөрчлийн байдал, түүний хэмжээ (төрийн өмчийн компаниудад 78 хувь, хувийн өмчийн компаниудад 60 хувь)-г харгалзан үздэг болох нь харагдаж байна (дүрслэл 3).

Дүрслэл 3

Дотоод аудитын арга зүйн хэрэглээ



Ийнхүү дотоод аудитын төлөвлөлтийн үндэслэл, хэрэгжүүлж буй горимуудаас үзвэл манай компаниудын дотоод аудитад уламжлалт арга зүй буюу аливаа үзүүлэлт, мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулахад чиглэсэн нотлох үйл ажиллагаа давамгайлж, бизнесийн бүх талын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдлийг илрүүлэх, түүнийг бууруулахад чиглэсэн арга зүйд шилжиж чадаагүй байна. Энэ нь эрсдэлд суурилсан дотоод аудитын арга зүйн талаар онолын судалгаа хийгдээгүй, төрийн болон мэргэжлийн байгууллагын зөвлөмж, практикт хэрэгжүүлэх гарын авлага байхгүйтэй холбоотой. Ялангуяа эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, эдгээр хүчин зүйлсийг үнэлэх, эрсдлийн үнэлгээнд суурилж аудитыг 3 McNamee D., Selim G.M. (1998). Risk Management: Changing the internal auditor's paradigm. Altamonte Springs, Florida, USA.

төлөвлөх ба хэрэгжүүлэх арга зүй, аргачлал нэн чухал шаардлагатай.

Хүний нөөц (дотоод аудитын ажилтан)

Дотоод аудиторуудын мэргэжлийн үр чадвар, мэргэшсэн байдал, ажлын түршлага нь компанид дотоод аудит үр ашигтай хэрэгжих нэг хүчин зүйл мөн. Судалгаанд хамрагдсан 25 компанид нийт 327 дотоод аудитор ажиллаж байгаагийн 54 хувь нь санхүү, нягтлан бодох бүртгэл, хуулийн мэргэжилтэй, 32 хувь нь инженер, 10 хувь нь мэдээллийн технологич, 1 хувь нь эмч зэрэг бусад мэргэжилтэй (дүрслэл 4) байгаас үзэхэд манай компаниудад ажиллаж байгаа дотоод аудиторуудын талаас илүү хувь нь санхүү, нягтлан бодох бүртгэл, хуулийн мэргэжилтэй бөгөөд гурван хүн тутмын нэг нь инженерийн мэргэжилтэй байна. Сүүлийн үед дотоод аудитор ажилд авахаар зарласан ТЭСО корпораци ХХК, АПУ ХК, Зээлийн батлан даалтын сан, Хасбанк, ХААН банк гэсэн таван байгууллагын зард “Дотоод аудитын дүрэм”-д заасан үндсэн 5 шаардлагаас “санхүү эдийн засаг, нягтлан бодох бүртгэл, хууль, мэдээллийн технологийн мэргэжилтэй”, “мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан” гэсэн шалгуурууд нийтлэг орсон байгаа нь үндсэн мэргэжлийн үр чадвар, мэргэжлээрээ ажилласан хугацаа нь дотоод аудиторын ажлын үндсэн шалгуур болж байгааг харуулж байна.

Дүрслэл 4

Дотоод аудиторуудын мэргэжлийн бүтэц



Харин “Дотоод аудитын дүрэм”-д заасан дотоод аудиторын сургалтанд хамрагдсан байдал, үнэнч шударга байх, цагдаагийн байгууллагын тодорхойлолттой байх гэсэн шаардлагуудаас илүүтэйгээр шинжилгээ хийж гүйцэтгэлийг хянах, дүгнэлт гаргах, удирдан зохион байгуулах, багаар ажиллах, өөрийгөө илэрхийлэх чадвар, албан бичиг, тайлан боловсруулах, компьютерын программууд

ашиглах дадал, англи хэлний мэдлэгийг нэмэлт шаардлага болгосон байна. Мөн хувь хүний хөгжил, ажилдаа хандах зөв хандлага, мэргэжлийн ёс зүйгээс гадна итгэл даах, нууц хадгалах зэрэг хувийн зан чанар нь дотоод аудиторүүдэд зайлшгүй байх ёстой гэж удирдлагууд үзэж байна.

Дотоод аудиторын мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх нь өмчлөгчид болон гүйцэтгэх удирдлагын өдөр бүр өсөн нэмэгдэж байгаа мэдээллийн эрэлтийг хангах, дотоод аудитын албаны үр ашгийг дээшлүүлэх үндсэн нөхцөл мөн. Өнөөдөр манай компаниудад дотоод аудиторын мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх үндсэн хэлбэр нь мэргэжлийн байгууллагын сургалт (80 хувь) болж байна. Дотоод аудитын сургалт явуулдаг мэргэжлийн байгууллага цөөн (Монголын дотоод аудиторуудын институт, Компанийн засаглалын хөгжлийн төв) байгаагаас тэр нь дотоод аудиторуудыг нийтлэг байдлаар хамарсан, мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх сургалтын оновчтой хэлбэр болж чадахгүй байна. Гэтэл олон улсын түвшинд дотоод аудиторуудын мэргэжлээ дээшлүүлэх үндсэн хэлбэр нь олон улсын ДАИ-ийн гишүүн болж, аудитын шинэ технологи, онол арга зүйн болон шаардлагатай бусад мэдээллийг авах явдал болсон. Иймд манай мэргэжлийн олон нийтийн байгууллагууд, дотоод аудиторууд олон улсын ДАИ-ийн гишүүнчлэлтэй болж тэдний онлайн хэлбэрээр түгээдэг онол, практикийн болон судалгааны материалуудаас суралцаж, мэргэжлийн үр чадвараа тасралтгүй дээшлүүлэх хэлбэрт шилжих шаардлагатай. Дотоод аудиторууд нь бизнесийн бүх үйл ажиллагаа, технологи, санхүүгийн мэдээлэл, хяналтын тогтолцоог бүрэн судалсан мэргэжилтнүүд байдаг тул нэгэнт сургаж авсан ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулж, тэдний бүтээмжийг ашиглах нь компанийн удирдлагын бас нэг чухал асуудал юм. Судалгаанд хамрагдсан дотоод аудиторуудын сэтгэл ханамжийн байдлаас үзвэл судалгаанд оролцсон дотоод аудиторуудын 50 хувь нь энэхүү албан тушаал нь ажилласнаар мэргэжлийн үр чадвараа дээшлүүлэх боломжтой, ирээдүйтэй ажил гэж үзэж байгаа бол 36 хувь нь бизнесийн олон талыг хамардаг сонирхолтой ажил, 14 хувь нь цалингийн хэмжээ их гэж хариулсан байна. Гэхдээ өнөөгийн практикт дотоод аудитыг үйл ажиллагааг сайжруулах зорилготой зөвлөх, туслах үйл ажиллагаа гэхээсээ илүү хяналт,

шалгалтын нэгж гэж үзэж байгаагаас хамт олны дунд нэр хүнд муутай ажил гэж дотоод аудиторууд өөрсдөө үздэг явдал байгаа нь ажиглагдлаа.

Дүгнэлт

- Манай компаниудад хэрэгжиж буй дотоод аудитын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны хамрах хүрээ, дотоод аудиторуудын талаар хийсэн судалгаанаас үзвэл толгой компанийн зүгээс салбар, охин компанийн удирдлагын үйл ажиллагааг хянах эрэлт нь дотоод аудиттай байх үндсэн хүчин зүйл болж байна. Компанийн үйл ажиллагаа өргөжин, салбар нэгжийн тоо нэмэгдэхийн хэрээр дотоод аудитын албаны хэмжээ том (олон дотоод аудитортой) байгаа бөгөөд компанид дотоод аудитын албаны ажилласан хугацаанаас хамаарч ажилтнуудын тоо нэмэгдэх хандлага байна.
- Компанийн дотоод аудитын нэгж нь толгой (төв) компанийн гүйцэтгэх удирдлагад харьяалагдаж, охин (салбар) компанийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, тэнд эрсдлийн удирдлага, дотоод хяналтын үр ашигтай тогтолцоо бүрдүүлэх үндсэн зорилготой ажиллаж байгаа нь манай компаниудын дотоод аудитын удирдлага, зохион байгуулалтын онцлог гэж үзэж болно.
- Манай компаниудын дотоод аудитын үйл ажиллагаанд санхүүгийн болон хууль зүйн нийцлийн дотоод аудит зонхилж байна. Гэхдээ санхүүгийн болон хууль зүйн нийцлийн аудитаар учирч болзошгүй эрсдэл, дотоод хяналтыг үнэлэхээс илүүтэйгээр бодит байдлыг шалгах, үнэлэлт өгөхөд чиглэсэн нотлох арга зүйг хэрэгжүүлж байгаагаас түүний хяналт шалгалтын үүрэг давамгайлж, зөвлөгөө өгөх, эрсдлээс урьдчилан сэргийлэх үүрэг бага байгаа нь харагдаж байна.
- Дотоод аудиторуудыг сургах, гэрчилгээ олгох, тасралтгүй боловсролыг хангах нэгдсэн тогтолцоо бүрдээгүйгээс дотоод аудиторуудын мэргэжлийн бэлтгэл, хангамж шаардлагын хэмжээнд хүрч чадахгүй байна. Компаниуд дотоод аудиторыг ажиллуулахдаа үндсэн мэргэжлийн үр чадвар, нэр хүнд, мэргэжлээрээ ажилласан хугацааг үндсэн шалгуураа болгогдийн зэрэгцээ тусгайлсан сургалтаар биш,

үндсэн ажлаа гүйцэтгэх замаар ажлын
дадал олж авах хэлбэр нийтлэг байна.

Ашигласан эх сурвалж

IIA. International standards for the professional
practice of internal auditing, The Institute of
Internal Auditors.2009 www.iaa.org.com

1. СЗХ. Монголын компанийн засаглалын
кодекс. 2014. www.frc.mn
2. СЗХ. Монгол улсын компанийн засаглалын
үндэсний тайлан. 2013
3. А.Өнөржаргал. Компанийн дотоод
аудитын онол, арга зүйн асуудал (нэг
сэдэвт бүтээл). 2014
4. Дотоод аудитын дүрэм. Засгийн газрын
129 тоот тогтоол. 2012
David Griffiths., Risk based internal auditing.
An introduction. [http://www.internalaudit.
biz](http://www.internalaudit.biz).
McNamee D., Selim G.M. Risk Management:
Changing the internal auditor's paradigm.
Altamonte Springs, Florida, USA. 1998
Эрнст энд Янг. Исследование текущего
состояния и тенденций развития
внутреннего аудита в России. 2009